

УСНЫ КОМПАКТ



“

Ус гүн цэвэршүүлэх
үйлдвэрийн тоног
төхөөрөмжүүдийн
суурилуулалтын
ажил үргэлжилж
байна

Ус гүн цэвэршүүлэх
үйлдвэрийн бүтээн
байгуулалтын ажил 2024
оны 10 дугаар сарын эцсийн
байдлаар 88%-д хүрлээ

Үргэлжлэл 2-р нүүрт

**“Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишиг:
Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг өргөн
хүрээтэйгээр сайжруулах нь” хэлэлцүүлэгт оролцлоо**



АНУ-ын Стратеги, олон улсын харилцааны хүрээлэн (CSIS)-ээс 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Вашингтон хотноо зохион байгуулсан “Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишиг: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг сайжруулах нь” хэлэлцүүлэгт Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл оролцлоо.

Үргэлжлэл 5-р нүүрт

**УСУГ-ын инженер,
техникийн ажилтнуудыг
чадавхжуулах ээлжит
сургалтыг Нидерланд улсад
зохион байгуулав**

Усны ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр (WOP)-ийн хүрээнд УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах дөрөв дэх сургалтын аялыг 10 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд Нидерланд улсад амжилттай зохион байгууллаа.

Үргэлжлэл 4-р нүүрт

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим куб метрээр нэмэгдэх юм.



Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн нийт гүйцэтгэл 78%-тай байна

Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд хэрэгжүүлж буй гурван гол төслийн нэг Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн бүтээн байгуулалтын нийт гүйцэтгэл 78%-д хүрээд байна. Энэ төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн 30 гүний худаг, 55 км ус дамжуулах шугам хоолой, түүнчлэн Монголын анхны Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг дагалдах дэд бүтцийн хамт барьж байгуулж байна.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажил үргэлжилж байна

Компакт гэрээний санхүүжилтээр барьж буй хоёр томоохон үйлдвэрийн нэг болох дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 2024 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 88%-д хүрлээ. Уламжлалт цэвэрлэгээний байгууламжийн барилга 93.06%, Цэвэршүүлсэн усны сан болон насос станцын барилга 95.02%,

Тунадас боловсруулах байгууламжийн барилга 84.04%, Цахилгаан/генераторын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 92.9%, Урвуу осмосын байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.7%-тай байна. Мөн гадна засал, тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажил үргэлжилж байна.

Шувуун фабрикийн эх үүсвэрийн ус дамжуулах шугам хоолойн угсралтын ажлын гүйцэтгэл 80.5%-д хүрэв



Газрын доорх усны эх үүсвэрийн худгууд, ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажлын нэгдсэн багцын "Баран групп" компанийн хариуцсан ажлын нийт гүйцэтгэл 64%-д хүрсэн байна. Шувуун фабрикийн эх үүсвэрийн ус цуглуулах шугам хоолойн угсралт 36.8, ус дамжуулах шугамын угсралт 80.5%-тай үргэлжилж байна. Шинэ эх үүсвэрийн худгууд болон харуулын байрны барилга угсралтын ажлууд, цахилгаан хангамжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хэвийн үргэлжилж байна.

ТОВЧХОН:

Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд нийт 55 км ус дамжуулах шугам хоолой барьж байгаа бөгөөд ундны ус дамжуулах зориулалттай, 100 жилийн эдэлгээтэй зөөлөн ширмэн хоолой (ductile iron pipe) ашиглаж байна.

Төслийн хүрээнд нийт 20 байршилд авто зам, гол, төмөр зам доогуур шугам хоолойн сүвлэгээг хийхээр төлөвлөсөн. Үүнээс Монголд анхны туршлага болох гол болон төмөр зам доогуурх сүвлэгээний ажлын бэлтгэл газар шорооны, хүчитгэлийн ажлуудыг гүйцэтгэж байна.

Биокомбинатын эх үүсвэрийн ус цуглуулах 5.1 км шугамыг суурилуулсан. 2024 оны зуны саруудад төслийн талбай үерт автсаны улмаас суурилуулсан шугам хоолойд эвдрэл гэмтэл гарсан эсэхийг шалгаж, өмнө нь гидравлик туршилт хийсэн байсан 2 км шугамыг цэвэрлэн ариутгал хийх шаардлагатай болсон. Одоогоор 1.3 км шугамын гидравлик тестийг дахин хийгээд байна.

97% ШУГАМ ХООЛОЙ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч БНТУ-ын "МАПА Иншаат вэ Тиажарет" компанийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу гүйцэтгэж буй шугам хоолойн барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 71%-д хүрлээ. Үүнээс Биокомбинатын эх үүсвэрийн ус дамжуулах шугам хоолойн суурилуулалтын ажил 97%-тай үргэлжилж байгаа бөгөөд 2024 оны 11 дүгээр сард багтааж дуусахаар төлөвлөж байна.


ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (“ХУДБУ”) болон дахин боловсруулсан усыг “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл куб метрээр бууруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 52%-тай үргэлжилж байна

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд барьж байгуулж буй технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 2024 оны 10 дугаар сарын сүүлийн байдлаар 52%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Технологийн есөн байгууламжаас шахуургын станц №1 57%, тогтворжуулах сан 72.4%, хөдөлгөөнт био реактор 53%, ламелла

тунгаагуурын байгууламжийн барилгын ажлын явц 47%-ийн гүйцэтгэлтэй байгаа бол ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилгын ажил 24%, халдваргүйжүүлэх сан 69%, шахуургын станц №2 47%, ус зайлуулах сангийн барилга угсралт 48%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Технологийн есөн байгууламжийн барилга угсралтын ажлыг 2024 оны барилгын улиралд, туслах найман байгууламжийн барилга угсралтын ажлыг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажил 62.5%-д хүрэв

Хаягдал ус дахин боловсруулах төслийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажил 2024 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар 65.5%-д хүрлээ. Барилга угсралтын ажлыг хоёр үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний үе шат буюу Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-4 ТӨХК рүү дахин боловсруулсан ус дамжуулах 4.4 км шугам хоолойн угсралт, дөрвөн худгийн бетон цутгалтын ажил, өргөлтийн шахуургын станц, ус нөөцлөх сан №1, 2-ийн бетон цутгалтын ажил 95%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Түүнчлэн ДЦС-4 ТӨХК-ийн лаборатори, холбогдох худгуудын барилгын ажил 17%, шугам хоолойн угсралтын ажил 88%-тай үргэлжилж байна. Хоёрдугаар үе шат буюу ДЦС-4 ТӨХК-аас ДЦС-3 ТӨХК хүртэлх шугам хоолойн барилга угсралтын ажил 23%, ДЦС-3 ТӨХК-ийн хашаанд явагдаж буй барилгын ажил 61%, шугам хоолой 56%, түүнчлэн Насос станц, Усан сангийн барилга угсралт 76%-тай байна.


“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага”-ыг холбогдох байгууллагуудад сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хурал боллоо



Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний (ҮХУЦТ) хэрэгжилтийг хэлэлцэж, “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага”-ыг холбогдох байгууллагуудад сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хурал 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр боллоо. Хуралд ҮХУЦТ

төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсэг, Төр, орон нутгийн хяналтын байгууллага, бохирдуулагч ангиллын үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус холбоод, байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Гарын авлагыг “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний (ҮХУЦТ) хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын Мянганы сорилтын сангийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд боловсруулсан юм.

 “Үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэх гарын авлага”-ыг Монголын МСС-ийн албан ёсны цахим хуудсаас татаж авах боломжтой.

 <https://mca-mongolia.gov.mn/>

УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ БОЛОВ

Уулзалтын үеэр “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явц, хаягдал усны шинэчилсэн стандарт болон Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага, ус цэвэрлэх байгууламж суурилуулах ерөнхий шат дараалал, урсгалын талаар болон Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөх тогтолцооны талаар танилцуулснаас гадна үйлдвэр, аж ахуйн нэгжүүд ус цэвэрлэх байгууламж байгуулахтай холбоотой туршлагаа хуваалцлаа.

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хэрэглэгчдэд үзүүлэх цахим үйлчилгээг сайжруулах төслийн оролцогч талуудын уулзалт боллоо

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах төслийн оролцогч талуудын уулзалтыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Улаанбаатар хотод ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч бүх байгууллага, 270 гаруй мянган айл өрх, ААН-ийн хэрэглэгчдийг нэгдсэн мэдээллийн систем, төлбөр төлөх систем, ухаалаг гар утасны аппликейшн, нэгдсэн

дуудлагын төвийн үйлчилгээнд холбож, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн цахим үйлчилгээг нэвтрүүлэх энэхүү ажлыг “Аствишн” компани хариуцан эхлүүлээд байна. Төслийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын захирмажаар байгуулсан бөгөөд тус Ажлын хэсгийн ахлагч Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин уулзалтыг нээж үг хэлэв.

Эдгээр системийг хэрэглээнд нэвтрүүлснээр нийслэлийн иргэдийн өдөр тутмын ажлыг илүү хялбарчлах, бүтээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой төдийгүй Улаанбаатар хотын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн байгууллагуудыг нэгдсэн стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, хэрэглэгчдэд өрхийн усны хэрэглээ, төлбөр, усны хязгаарлалт болон бусад үйлчилгээтэй холбоотой мэдээллийг цаг тухайд нь өгөх боломж бүрдэх юм.

УСУГ-ын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах ээлжит сургалтыг Нидерланд улсад зохион байгуулав



Түрүүч нь 1-р нүүрт

Хөрөнгийн менежмент, Байгаль орчны менежмент, Онцгой байдлын төлөвлөлт гэсэн гурван үндсэн чиглэлээр зохион байгуулсан энэ удаагийн сургалтад Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газрын 19 инженер, техникийн ажилтан хамрагдаж, Нидерландын ус ашиглалтын байгууллагуудын ментор, экспертүүдтэй мэдлэг, туршлагаа солилцов. Түүнчлэн Хөрөнгийн менежментийн баг дэлхийн тэргүүлэх усны боловсрол олгох байгууллага болох “IHE Delft Institute for Water Education” институтын тусгайлан зохион байгуулсан сургалтад хамрагдаж, 24 кредит цагийн мэргэжлийн хичээлийг

амжилттай судлан сертификат гардаж авлаа.

Оролцогчид сургалтын төгсгөлд үндсэн сэдвүүдээс гадна төслийн удирдлагын сургалт, Нидерландын усны байгууллагууд, талбай, сайтаар зочилж, технологийн шинэчлэлүүдтэй танилцаж олж авсан үнэ цэнтэй мэдлэг мэдээллийг онцолж байв. Түүнчлэн сурсан мэдсэнээ бусдадаа хуваалцан байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлж, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулахаар төлөвлөгөө гарган танилцуулсан юм.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааг таниулан сурталчлахад Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран ажиллана



Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд Монголын Мянганы сорилтын сангаас дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Монголын Мянганы сорилтын сан нь Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдлэг, ойлголтыг түгээх зорилго бүхий зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Хэвлэлийн Хүрээлэнтэй байгууллаа.

Дэлхийн ядуурлыг бууруулах өдөр: Ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрт 17 тэрбум ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилт олгожээ



Эдийн засгийн өсөлтөөр ядуурлыг бууруулах зорилготой Мянганы сорилтын корпорац нь 2004 онд байгуулагдсан АНУ-ын Засгийн газрын хөгжлийн агентлаг юм. 2024 онд Мянганы сорилтын корпорацын 20 жилийн ой тохиож байна. Мянганы сорилтын корпорац нь 20 жилийн

түүхэндээ ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрт 17 тэрбум ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилт олгож, түүний үр шимийг дэлхийн 48 орны 400 орчим сая хүн хүртээд байна.

“Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулав



“Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас салбарын онцлогтоо нийцүүлэн анхны жишиг “Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт” болон “Ажилчдын байрны

шалгах хуудас”-ыг батлан хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Монголын Мянганы Сорилтын сан хооронд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу гарын авлага, зурагт хуудас боловсруулах талаар талуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Жендэрийн орон тооны бус салбар зөвлөл, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй байгууллагуудын төлөөлөл оролцож, санал бодлоо солилцов.

Ирээдүйн хүрээлэн буй орчны инженерүүд Усны Компакттай танилцав



Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн Хүрээлэн буй орчны инженерчлэлээр суралцагч оюутнууд Усны Компактын хүрээнд барьж буй Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн

байгуулалттай танилцлаа. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “М Си Эс Проперти” ХХК-ийн Ахлах инженер А.Анхбаяр үйлдвэрийн дизайн шийдэл, бүтэц зохион байгуулалт, ажиллагааны талаар танилцуулж, Халаалт агаар сэлгэлтийн инженер Н.Дармаадалай хөтөчлөн барилгын үйл явц, технологийн талаар мэдээлэл өгсөн юм. Багш Ц.Ариунтуяа болон оюутан залуусын зүгээс тус үйлдвэр хүрээлэн буй орчны бохирдлыг хянах, бууруулах, нөхөн сэргээхэд хэрхэн хувь нэмэр оруулах талаар асууж, туршлага судлав.

МСК-ын төлөөлөл Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзав




АНУ-ын Мянганы сорилтын корпорацын (МСК) Дэд ерөнхийлөгч бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Питер Жаффе болон Туслах Хуулийн ерөнхий зөвлөх Дэвид Кассебаум нар Монгол Улсын Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Монголын Мянганы сорилтын сангийн Удирдах зөвлөлийн дарга Ж.Ганбат болон бусад удирдах зөвлөлийн гишүүд, Монголын Мянганы сорилтын сангийн удирдлагуудтай уулзаж, Усны Компакт гэрээний хэрэгжилт, үр дүнгийн талаар ярилцан, санал солилцлоо.

“Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишиг: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг өргөн хүрээтэйгээр сайжруулах нь” хэлэлцүүлэгт оролцлоо

Түрүүч нь 1-р нүүрт

АНУ-ын Стратеги, олон улсын харилцааны хүрээлэн (CSIS)-ээс 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Вашингтон хотноо зохион байгуулсан “Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шинэ жишиг: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг өргөн хүрээтэйгээр сайжруулах нь” хэлэлцүүлэгт Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э. Энхгэрэл АНУ-ын Мянганы сорилтын корпорац, Олон улсын хөгжлийн агентлаг, Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорац, Далай, агаар мандлын үндэсний алба, Армийн инженерийн корпусын төлөөллийн хамт оролцож, Усны Компактын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнд Улаанбаатар хотын ус хангамжийн тогтвортой байдлыг хэрхэн хангах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг хэрхэн сайжруулах талаар мэдээлэл хуваалцлаа.

Компакт гэрээ хэрэгжиж дуусахад



хугацаа үлдлээ